



## ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Авлигын эсрэг бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.13 дахь заалт, Монгол Улсын Их хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн 8.1.1 дэх заалт, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн дүрмийн 9.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Авлигын эсрэг бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.
2. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, дээрх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Э.Тамир)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Л.Амгалан) -д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



*М. Батбаяр* Ц.ТҮВШИНЗАЯА



“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдрийн ... тоот тогтоолын хавсралт

## “ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН АВЛИГЫН ЭСРЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ (2025-2028)

### Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1.1. “Төрийн орон сууцны корпораци” (цаашид “Бодлогын баримт бичиг” гэх ) ТӨХХК нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Орлогод нийцсэн орон байр” бодлого<sup>1</sup>-ыг хэрэгжүүлэхдээ Авлигагүй засаглалыг<sup>1 2</sup> бэхжүүлж, аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс ангид байх эрх зүйн орчин, шударга ёсны тогтолцоог Авлигын эсрэг менежментийн тогтолцоо MNS ISO 37001:2024-д заасны дагуу бүрдүүлэх, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хандлага, Авлигын эсрэг соёлыг төлөвшүүлэх зорилгоор дунд хугацааны стратегийн түвшинд хэрэгжүүлэхээр дэвшүүлэн тавьж буй бодлого юм.

1.2. Энэхүү Авлигын эсрэг бодлогын баримт бичиг нь Монгол Улсын Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүчин зүйлийг судалж, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах, бууруулах, таслан зогсооход чиглэсэн тогтвортой, уялдаа холбоотой “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн удирдлага, зохион байгуулалтын газар, нэгжүүд болон төсөл хэрэгжүүлэх нэгж, ажилтан бүр хэрэгжүүлэх цогц арга хэмжээ мөн.

1.3. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн ажилтан бүр Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгоно.

1.4. Компанийн нийт ажилтнууд энэхүү бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон конвенц, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтууд болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөнө.

1.5. Энэхүү Авлигын эсрэг бодлогын баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт тухайлан заасан “Үндэсний баялгийн сан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлж...”, “... иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж,

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2020 оны 05 сарын 30-ны өдөр. Дугаар 52. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Зорилт 3.2.

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2020 оны 05 сарын 30-ны өдөр. Дугаар 52. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Зорилт 5.6.



орон сууцжуулалтыг эрчимжүүлэх”<sup>3</sup>, Өрхийн төлбөрийн чадварт нийцүүлж ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх”<sup>4</sup>, “Үндэсний орон сууцны корпораци байгуулж, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг үе шаттайгаар Засгийн газарт шилжүүлэх ажлыг зохион байгуулах”<sup>5</sup> бодлогуудтай уялдсан байна.

1.6. Авлигын эсрэг бодлогын баримт бичиг нь Авлигын эсрэг менежментийн тогтолцоо MNS ISO 37001:2024-д заасан шаардлагад бүрэн нийцсэн байна.

## Хоёрдугаар бүлэг

### Бодлогын баримт бичигт хэрэглэх нэр томьёо

Авлигын эсрэг бодлогын баримт бичигт Монгол Улсын хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад<sup>6</sup> заасан шаардлагад нийцсэн хууль тогтоомжид заасан нэр томьёог шууд авч хэрэглэнэ.

2.1. MNS ISO 37001:2024-д заасан зарим нэр томьёог “нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх”-аар<sup>7</sup> хэрэглэнэ.

2.1.1. MNS ISO 37001:2024. 3.1. “**Авлига**”- Аливаа хувь хүн өөрийн албан чиг үүргээ биелүүлсэн эсхүл биелүүлээгүйн төлөө түүнд хамаарах гүйцэтгэл (3.16)-тэй холбоотойгоор үнэ цэнэ бүхий зүй бус (санхүүгийн болон санхүүгийн бус) давуу байдлыг хууль тогтоомжийг зөрчин, байршлаас үл хамаарч шууд эсхүл шууд бусаар шагнал, урамшуулал хэлбэрээр санал болгох, амлах, өгөх, хүлээн авах буюу шаардах;

2.1.2. MNS ISO 37001:2024. 3.3 “**Оролцогч тал**”-шийдвэр эсхүл үйл ажиллагаанд нөлөөлөх, нөлөөнд өртөж болох, эсхүл өөрийгөө нөлөөнд өртөнө гэж ойлгож буй хувь хүн эсхүл байгууллага (3.2)

2.1.3. MNS ISO 37001:2024. 3.4 “**Шаардлага**” тогтоосон болон заавал биелүүлэх хэрэгцээ;

2.1.4. MNS ISO 37001:2024. 3.5 “**Менежментийн тогтолцоо**” бодлого (3.10), зорилго (3.11), тэдгээр зорилгод хүрэхэд чиглэсэн үйл явцуудыг (3.15) бий болгох харилцан хамаарал, уялдаа холбоо бүхий байгууллагын (3.2), бүрдэл хэсгүүдийн багц;

2.1.5. MNS ISO 37001:2024. 3.6 “**Дээд удирдлага**” байгууллагыг (3.2)-ыг дээд түвшинд удирдан чиглүүлж, хянах хувь хүн эсхүл бүлэг хүмүүс;

2.1.6. MNS ISO 37001:2024. 3.9 “**Үр нөлөөтэй байдал**” төлөвлөсөн үйл ажиллагааны биелэлт, төлөвлөсөн үр дүнд хүрсэн хэмжээ;

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2.4.1.1 дэх заалт

<sup>4</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2.4.1.2 дахь заалт.

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2.4.1.3 дахь заалт.

<sup>6</sup> Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1.”Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх”;

<sup>7</sup> Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт.

2.1.7. MNS ISO 37001:2024. 3.10 **”Бодлого”** байгууллагын (3.2) дээд удирдлага (3.6) болон удирдах бүлэг (3.7)-ээс албан ёсоор илэрхийлсэн байгууллагын зорилт, чиглэл;

2.1.8. MNS ISO 37001:2024. 3.11 **”Зорилго”** зорьж буй үр дүн;

2.1.9. MNS ISO 37001:2024. 3.15 **”Үйл явц”** оролтыг гаралт болгон хувиргах холбоо хамаарал, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа;

2.1.10. MNS ISO 37001:2024. 3.16 **”Гүйцэтгэл”** хэмжиж болохуйц үр дүн;

2.1.11. MNS ISO 37001:2024. 3.18 **”Хяналт шинжилгээ”** тогтолцоо, үйл ажиллагаа, үйл явцын (3.15) нөхцөл байдлыг олж тогтоох;

### **Гуравдугаар бүлэг Бодлогын зарчим**

3.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.1.1. Хууль дээдлэх;

3.1.2. Монгол Улсын Авлигатай тэмцэх төрийн бодлоготой уялдсан байх;

3.1.3. Олон улсын Авлигын эсрэг стандартын шаардлагад нийцсэн байх;

3.1.4. Шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа шинжилгээнд суурилсан байх;

3.1.5. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь цогц, тасралтгүй байх;

3.1.6. Компанийн бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг, хөгжлийн бодлого, сайн засаглалыг зарчимд нийцсэн байх;

3.1.7. Компанийн нийт ажилтнуудын хүний эрх эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан нэр төр, алдар хүнд, жендерийн тэгш эрхийг хамгаалдаг байх;

3.1.8. Цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, өөрчлөгддөг байх;

3.1.9. Олон нийтийн оролцоо дэмжлэгт түшиглэсэн, шударга ёсыг дэмждэг байх;

### **Дөрөвдүгээр бүлэг**

#### **Бодлогын зорилго, зорилт**

4.1. Авлигын эсрэг бодлогын зорилго нь “Хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, ажилтанд Авлигын эсрэг ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

4.2. Бодлогын зорилт нь дараах чиглэлтэй байна. Үүнд:

4.2.1. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгож, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг бэхжүүлэх;

4.2.2. MNS ISO 37001:2024 стандартын шаардлагад нийцсэн Авлигын эсрэг менежментийг тогтолцоог хэрэгжүүлэх;

4.2.3. Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж<sup>8</sup>, ажилтнуудын Авлигын эсрэг эрх зүйн боловсролыг дээшлүүлэх<sup>9</sup>;

4.2.4. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгох<sup>10 11</sup>;

## Тавдугаар бүлэг

### Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

**Зорилт-1.** 5.1. “Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгож, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг бэхжүүлэх” зорилтын хүрээнд:

5.1.1. Компанийн хэмжээнд Авлигын эсрэг нийцлийн чиг үүрэг бүхий нэгжийг<sup>11</sup> шинээр бий болгон, Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгон, нэгдсэн бодлогоор үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж хэвшүүлэх;

5.1.2. Үндэсний орон сууцжуулалтын тогтолцоог шинээр бий болгох, орон сууцжуулалтын хууль тогтоомжид орох өөрчлөлттэй уялдуулан, Авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг урьдчилан судалж, эрсдэлийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх;

5.1.3. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх үйл ажиллагааг үе шаттайгаар эхлүүлэх;

5.1.4. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг компанийн гадаад, дотоод оролцогчид болон Авлигын эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийн дэмжлэгийг авч, нээлттэйгээр хамтран ажиллах;

5.1.5. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтнуудаа чадавхжуулах;

**Зорилт-2.** 5.2. “MNS ISO 37001:2024 стандартын шаардлагад нийцсэн Авлигын эсрэг менежментийг тогтолцоог хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд:

5.2.1. Компанийн хэмжээнд MNS ISO 37001:2024 стандартын тогтолцоог бий болгохдоо мэргэжлийн байгууллагуудын сургалт, зөвлөх үйлчилгээг авч, удирдах болон бусад ажилтнуудаас дотоод аудиторуудыг бэлтгэх замаар хэрэгжүүлэх;

5.2.2. Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудтай<sup>12</sup> бодлого, үйл ажиллагаагаа уялдуулан, нэгдсэн менежментийн стандартын ISO 9001, ISO 37301, ISO 37001 тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлэх;

<sup>8</sup> Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр. 4.1.8.4. “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах”;

<sup>9</sup> Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр. 4.1.10. “Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх

<sup>10</sup> Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр. 4.1.5.15. “аливаа хууль бус нөлөөлөл, түүний хэлбэрүүдийг тодорхойлж, түүнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох”;

<sup>11</sup> MNS ISO 37001:2024. 5.3.2 дахь заалт.

<sup>12</sup> Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр. Зорилго 8. “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн ил тод, үр ашигтай, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.”

5.2.3. Авлигын эсрэг менежментийн тогтолцоонд хамаарах асуудлаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох дүрэм журмыг батлуулж мөрдөх;

5.2.4. Энэхүү бодлогын баримт бичгийг болон Авлигын эсрэг менежментийн тогтолцоонд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалд дүйцүүлэн шинээр боловсруулж, үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэх;

**Зорилт-3.** 5.3. “Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, ажилтнуудын Авлигын эсрэг эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд;

5.3.1. Компанийн нийт ажилтнуудын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, Авлигын гэмт хэргээс өөрийгөө болон бусдыг хамгаалах арга зүй, хууль тогтоомжийг нэг мөр ойлгох чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулж, мэдээллэх;

5.3.2. Компанийн цахим хуудаст Авлигын эсрэг буланг ажиллуулж, иргэд олон нийтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мэдээллээр хангах, компанийн бизнесийн үйл ажиллагааг ил тод нээлттэйгээр<sup>13</sup> явуулах, нийгмийн нэр хүндийг өргөх талаар тодорхой ажлуудыг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллах;

5.3.3. Ажилтнуудаа Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зан үйл, ёс суртахуунд нөлөөлж байгаа хандлагыг өөрчлөх замаар нөлөөллийн арга хэмжээг сар бүр зохион байгуулж, холбогдох зардлыг зохих журмын дагуу төлөвлөн, хэрэгжүүлдэг байх;

5.3.4. Компанийн хэмжээнд “Авлигагүй бүс” бий болгож, Авлигын эсрэг сурталчилгааны самбар, соён гэгээрүүлэх ухуулга сурталчилгааны зориулалт бүхий нийтлэл, дүрс бичлэг, бусад мэдээллүүдийг байршуулж, ажилтнуудынхаа сэтгэл зүй, зан төлөвт эергээр нөлөөлөх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

**Зорилт-4.** 5.4. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгох; зорилтын хүрээнд:

5.4.1. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Авлигын эсрэг менежментийн тогтолцоонд хамаарах асуудлаар бизнесийн болон хөдөлмөрийн харилцааны эрх зүйн бичиг баримтууд, дотоод хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдэд өөрчлөлт, нэмэлт оруулж, эрх зүйн зөрчилгүй ажиллах;

5.4.2. Авлигын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх, чиг үүргийг компанийн хэмжээнд эрх зүйн бичиг баримтууддаа тодорхой болгож, Авлигын гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий албан тушаалтнуудын нэгдсэн жагсаалт гаргаж, манлайллыг хангаж ажиллах, ажлын байрны тодорхойлолтод тусгах;

<sup>13</sup> Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр.4.1.8.4.төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах;

5.4.3. Авлигын сэдэл, сэжиг бүхий үйлдэл, завдлын талаар мэдээллээгүй, нуун дарагдуулсан ажилтанд хариуцлага тооцох эрх зүйн орчныг бий болгож, зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг тогтмолжуулах;

5.4.4. Компанийн хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах, дотоод хяналтын системийг сайжруулах;

5.4.5. Авлигын эсрэг мэдээллийг хүлээн авах, мэдээлэл дамжуулах, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах эрх зүйн этгээдийг томилох, хяналтын давхар тогтолцоог бий болгох;

### **Зургаадугаар бүлэг**

#### **Авлигын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

6.1. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийг бий болгон ажиллах бөгөөд зохион байгуулалтын газар, төслийн нэгжүүд нь Авлигын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх мэргэжил арга зүйн удирдлагаар ажилтнуудаа хангах, бодлогын хэрэгжилт, үр дүнг компанийн Гүйцэтгэх захирлын өмнө хариуцна.

6.2. Компанийн Гүйцэтгэх захирал нь Авлигын эсрэг бодлогын хэрэгжилтийн талаар тайлагнах, үр дүнг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өмнө хариуцна.

6.3. Авлигын эсрэг бодлого нь компанийн удирдлага, зохион байгуулалтын газар, төслийн нэгжүүд болон тэдгээрт ажиллаж буй нийт ажилтнуудад хамаарна.

6.4. Компанийн нийт ажилтнууд нь Гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөдөлмөрийн болон Иргэний гэрээ эрх зүйн харилцааны үр дүнг үнэлэх, хариуцлага тооцох, шагнаж урамшуулах үндэслэлд энэхүү бодлогын баримт бичиг багтана.

### **Долоодугаар бүлэг**

#### **Авлигын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх үе шат, шалгуур**

##### **үзүүлэлт, хүрэх үр дүн**

7.1. Энэхүү Авлигын эсрэг бодлогыг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

**Нэгдүгээр үе шат /2025-2026/:** Авлигын эсрэг бодлогын үндэс суурийг бүрдүүлэх, тогтолцоог бий болгох, соён гэгээрүүлэх ажилтныг чадавхижуулах үйл ажиллагааг эхлүүлэх;

**Нэгдүгээр үе шатанд хүрэх үр дүн:**

7.1.1. Компанийн хэмжээнд Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинтой болсон байна.

7.1.2. Авлигын эсрэг менежментийн тогтолцооны олон улсын стандартад заасан шаардлагад нийцсэн байна.

**Хоёрдугаар үе шат /2027-2028/:** Нэгдүгээр үе шатанд бий болсон тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, ил тод байдлыг нэмэгдүүлэх;

### **Хоёрдугаар үе шатанд хүрэх үр дүн:**

7.1.3. Компанийн хэмжээнд Авлигатай тэмцэх төрийн бодлого, зорилтууд хэрэгжсэн байна.

7.1.4. Компанийн ил тод нээлттэй засаглал бий болж, олон нийтийн дунд нэр хүнд дээшилсэн байна.

7.1.5. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж тогтмол хэрэгждэг соёл бий болсон байна.

7.1.6. Компанийн хэмжээнд хүний эрх эрх чөлөө хангагдаж, Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэлбэр боловсронгуй болж, үүрэг хариуцлага нэмэгдэж, бизнесийн үйл ажиллагаанд Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэргүүлэх чиглэл бий болсон байна.

## **Наймдугаар бүлэг**

### **Санхүүжилт**

8.1. Авлигын эсрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

8.1.1. Компанийн бизнесийн болон үйл ажиллагааны төсөв.

8.1.2. Бусад хууль ёсны эх үүсвэрүүд;

### **Есдүгээр бүлэг**

#### **Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй**

9.1. Компани нь батлагдсан аргачлалын дагуу бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. Үүнд:

9.1.1. Авлигын эсрэг бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ;

9.1.2. Авлигын эсрэг менежментийн тогтолцооны дотоод аудит;

9.2. Компани нь Авлигын эсрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг жил бүр Төлөөлөн Удирдах Зөвлөлд хүргүүлнэ.

9.3. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Авлигын эсрэг бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж тайланг Хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

9.4. Авлигын эсрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хөндлөнгийн судалгааны баг, мэргэжлийн байгууллагуудаар үнэлгээ хийлгэж болно.

**"Төрийн орон сууцны борлуулалт ТӨХХК-ийн авлигын эсрэг бодлогын баримт бичгийн Хавсралт-1**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин				Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл үргэлжлүүлэх хугацаа	Хариуцах эзэн
				2025 он	2026 он	2027 он	2028 он					
<p align="center"><b>Авлигын эсрэг бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b></p>												
<p align="center"><b>Нэг. "Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгож, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг бэхжүүлэх"</b></p>												
1.1	MNS ISO 37001:2024 стандартын хэрэгжилт, баталгаажуулалт	Хувь	50	60	80	90	100	Олон улсын стандартын шаардлагад нийцүүлсэн байна	Аудитын тайлан	Дотоод/гадаад аудит	УЖИД-ИДЭР ХОТЭНЧУБА ТМ18179-Д 574553	АЭНЧУБА
1.2	Ажилтнуудын сургалтад хамрагдсан хувь	Хувь	30	70	85	90	95	Жилд 2 удаа сургалт явуулсан хувийг харьцуулж гаргана.	Сургалтын бүртгэл	Санал асуулга	Хүний нөөц сургалт хэрэгжилтэн	АЭНЧУБА
1.3	Орон сууцнуудын эрсдэлийн судалгааны тоо	Тоо	0	1	2	5	7	Жилд хийгдэх судалгааны тоо	Судалгааны тайлан	Эрсдэлийн матриц, өргөцлөл	6 сард 1 удаа	АЭНЧУБА
1.4	Хамтын ажиллагааны гэрээний тоо	Тоо	0	1	2	3	5	ТББ, төрийн байгууллагуудтай хамтран ажилласан тоо	Гэрээний бүртгэл, баримт бичиг	Баримт бичгийн шалгалт	Жилд 1 удаа	АЭНЧУБА, Гэрээ, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
1.5	Авлигын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	0	70	80	90	100	Жилд 2 удаа гаргасан тайлангийн биелэлтийн хувь	Төлөвлөгөөний тайлан	Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ	Жилд 2 удаа	АЭНЧУБА, Дотоод аудитор
<p align="center"><b>Хоёр. "MNS ISO 37001:2024 стандартын шаардлагад нийцсэн Авлигын эсрэг менежментийг тогтолцоог хэрэгжүүлэх"</b></p>												
2.1	Менежментийн тогтолцооны дотоод аудитын тоо	Хүн	8	3	5	5	10	Менежментийн тогтолцооны гэрчилгээтэй аудитын тоо	Сургалтын гэрчилгээ	Баримт бичиг	Жилд 1 удаа	Ажлын хэсэг
2.2	ISO 37001 сургалтад хамрагдсан ажилтны тоо	Хүн	15	50	70	85	95	Нийт ажилтны сургалтын тоо хамрагдалт	Сургалтын бүртгэл	Санал асуулга	6 сард 1 удаа	Хүний нөөц сургалт хариуцсан мэргэжилтэн
2.3	ISO 9001, 37001, 37001 интеграци хийсэн байдал	Хувь	0	30	60	85	100	Стандартуудын нийцлийн үнэлгээ	Аудитын тайлан	Гадаад аудит	Жилд 1 удаа	Менежментийн тогтолцооны дотоод
2.4	Аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	Тоо	0	2	4	6	8	Засгийн газрын 43 дугаар тогтоолд нийцсэн эсэх	Тайлан	Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ	Улиралд 1 удаа	Менежментийн тогтолцооны дотоод
<p align="center"><b>Гурав. "Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, ажилтнуудын Авлигын эсрэг эрх зүйн боловсролыг дээшлүүлэх"</b></p>												
3.1	Сургалтад хамрагдсан ажилтны хувь	Хувь	30	60	80	90	95	Жилд 2 удаа сургалтад хамрагдсан хувь	Сургалтын бүртгэл	Тест, санал асуулга	6 сард 1 удаа	Хүний нөөц сургалт хариуцсан мэргэжилтэн
3.2	Цахим порталын ашиглалт 1000 хүнээс тугамд эзлэх	Хувь		100	100	100	100	Иргэдийн цахим хандлагын түвшин	Веб анализ	Дотоод аудит	Улиралд 1 удаа	Дотоод аудитор
3.3	Ил тод байдлын индекс	Хувь	85	85	90	95	100	Шарвдалаг хангасан нийтлэгдсэн мэдээллийн индекс	ЦХХЯ-ны үнэлгээний тайлан	Дотоод аудит	Улиралд 1 удаа	Дотоод аудитор
3.4	"Авлиггүй бус" бий болгож сургалт сурталчилгаа явуулсан тоо, дүнгийн үзүүлэлт	Тоо	-	30	50	70	85	Сургалтын дараах өөрчлөлтийн түвшин, сургалт арга хэмжээний тоо	Судалгааны тайлан	Санал асуулга	Жилд 1 удаа	АЭНЧУБА, Хүний нөөц сургалт хариуцсан мэргэжилтэн
<p align="center"><b>Дөрөв. "Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгох"</b></p>												
4.1	Авлигын гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий албан тушаалтнуудын нэгдсэн жагсаалт, ажлын байрны тодорхойлолтод тусгасан байдал	Тоо	0	12	15	15	15	Жил бүрийн эрсдэлийн үнэлгээг гарсан эрсдэл бүхий албан тушаалын тоон мэдээлэл	Эрсдэлийн тайлан	Эрсдэлийн үнэлгээ	жилд 1 удаа	АЭНЧУБА, Ажлын хэсэг
4.2	Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт өрсөн журмын тоо /Авлигын талаарх мэдээлэл хүлээн авах, бүртгэх, хянах дотоод журам/	Тоо	0	10	5	7	15	Хууль тогтоомжийн нийцэл	Журам, заавар	Дотоод аудит	Улиралд 1 удаа	АЭНЧУБА, Ажлын хэсэг
4.3	Мэдээлэл өгөөгүй ажилтанд хариуцлага тоосон болон мэдээлэл хүлээн авч арга хэмжээ авсан тохиолдлын тоо	Тоо	0	Зөрчилгүй ажилласан байна	Зөрчилгүй ажилласан байна	Зөрчилгүй ажилласан байна	Зөрчилгүй ажилласан байна	Бүртгэгдсэн мэдээллийн тоо	Холбогдох журмын бүртгэлийн маяг, тайлан	Дотоод аудит	жилд 1 удаа	АЭНЧУБА, Ажлын хэсэг
4.4	Мэдээллийн аюулгүй байдлын талаар илрүүлсэн зөрчлийн тоо, зөрчлийг арилгасан хувь	Тоо	0	Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийг ажилласан байна	Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийг ажилласан байна	Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийг ажилласан байна	Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийг ажилласан байна	Бүртгэгдсэн зөрчлийн тоо	Аудитын тайлан	Дотоод аудит	Жилд 2 удаа	Дотоод аудитор
4.5	Авлигын эсрэг хяналтын үр нөлөөний талаарх ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшин	Хувь	0	70	80	90	100	Арга хэмжээ авч ажилласан байдал	Зөвлөмжийн биелэлтийн тайлан	Дотоод аудит	Жилд 2 удаа	АЭНЧУБА

**"ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ" ТӨХЖК-ИЙН  
АВЛИГЫН ЭСРЭГ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

**ТӨЛӨӨЛӨН  
УЛИРДАХ  
ЗӨВЛӨГ**

**УЛААНБААТАР ХОТ  
Төсөв /мян.төг/ 5535**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Үндэслэл/Шаардлага	Санхүүжилтийн	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
			хугацаа (оноор)			

**Нэг. "Авлигын эсрэг менежментийн тогтолцоог боловсронгуй болгох"**

1.1	ISO 37001 стандартын сургалт, зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээний гэрээний үлдэгдэл төлбөр /2024.09.04-ны өдрийн 2024/1-31 тоот 13,750,000 төгрөгийн гэрээ/	2025-2026	9,625.0	1	9,625.00
1.2	Дотоод аудитор бэлтгэх сургалт	Олон улсын стандартын академийн сургалт	2025-2028	450.0	10	4,500.00
1.3	ISO 37001 стандартын баталгаажуулалт	Стандарт хэмжил зүйн газар	2025	12,250.0	1	12,250.00
<b>Хэсгийн дүн</b>						<b>26,375.00</b>
<b>Хоёр. "MNS ISO 37001:2024 стандартын шаардлагад нийцсэн Авлигын эсрэг менежментийг тогтолцоог хэрэгжүүлэх"</b>						
2.1	Мэдээллийн ил тод байдлын портал хөгжүүлэлт	ТОСК ТӨХЖК-ийн цахим хуудас дахь Авлигатай тэмцэх буланд мэдээлэл, сурталчилгааг шинэчлэх ажлыг холбогдох мэргэжилтэн хариуцан гүйцэтгэнэ.	2026-2027	-	0	-
2.2	ISO 9001, 37001, 37301 интеграци хийх	Зөвлөх үйлчилгээг хуулийн дагуу сонгон шалгаруулж авна.	2026-2027	13,750.0	2	27,500.00
2.3	Нэгдсэн менежментийн тогтолцооны дотоод аудитор бэлтгэх сургалт	Олон улсын стандартын академийн сургалт	2026-2027	1,450.0	3	4,350.00

<b>Хэсгийн дүн</b>								<b>31,850.00</b>
<b>Гурав. "Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, ажилтнуудын Авлигын эсрэг эрх зүйн боловсролыг дээшлүүлэх"</b>								
3.1	"Авлигагүй бус" орчин нөхцөлийг бүрдүүлж сургалт сурталчилгаа явуулах /мэдээллийн самбар хийх/	Компанийн оффисын нэг давхарт мэдээллийн самбар байршуулна /10*150 хэмжээтэй самбар/	2025	1,500.0	1			1,500.00
3.2	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх ухуулга сурталчилгааны дүрс бичлэг хийх, нийтлэх	ТОСК ТӨХКК-ийн цахим хуудас дахь Авлигатай тэмцэх буланд компани АТМТ-г нэвтрүүлж, авлигатай тэмцэж байгаа тухай сурталчилгаа, мэдээллийг боловсруулж оруулна. 1-3 минутын дүрс бичлэгийг жилд 1 удаа, жил бүр шинэчлэн хийнэ.	2025-2028	1,500.0	6			9,000.00
<b>Хэсгийн дүн</b>								<b>10,500.00</b>
<b>Дөрөв. "Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгох"</b>								
4.1	Эрсдэлт өндөр ажлын байрны сургалт	АТГ, Цагдаагийн газар болон бусад сургалтын байгууллагаас сургалтыг жилд 1 удаа авна	2025-2028	500.0	3			1,500.00
4.2	Нийт ажилтны сургалт нөлөөллийн арга хэмжээ	АТГ, Цагдаагийн газар болон бусад сургалтын байгууллагаас жилд 2-оос доошгүй удаа сургалт авч, сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.	2025-2028	500.0	3			1,500.00
<b>Хэсгийн дүн</b>								
<b>НИЙТ ДҮН</b>								

